



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/02/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.5.1 Төсвийн төлөвлөлт	9
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	10
3.5.3 Нэмэлт төсөв	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5. 3 Зөвлөмж	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ТББ	Төрийн бус байгууллага
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.14 № 4/26
танай _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨР, ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2022 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 165 иргэнд 800.0, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөлбөрөөр 42 иргэнд 160.0, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээгээр 67 иргэнд 225.0, эмэгтэйчүүдийн хөтөлбөрт 1 иргэнд 10.0, малжуулах хөтөлбөрөөр 73 иргэнд 365.0, гэрээт малчин хөтөлбөрөөр 6 иргэнд 24.0, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гарааны бизнест /START-UP/ 1 иргэнд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулан 2,396.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж батлагдсан төсвийг 111.8 сая төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 260 иргэний зээлийн эргэн төлөлтийн 462.7 сая төгрөгийн хугацаа хэтэрснээс тайлант онд 166 иргэний 235.3 сая төгрөгийн зээлийг сангийн дансанд төвлөрүүлэн авлагыг бууруулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн авлага данс нь 3,429.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 42 иргэний 865.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, 27.4 сая төгрөгийн 20 иргэн нас барсан, 415.0 сая төгрөгийн 241 иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

021020146

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,679,778,225	3,429,783,930
33	АВЛАГА	2,654,576,140	3,429,783,930
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,665,000	9,520,000
335	Бусад авлага	2,651,911,140	3,420,263,930
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,651,911,140	3,420,263,930
34	УРЬДЧИЛГАА	19,719,585	-
34600	Урьдчилж гарсан зардал	19,719,585	-
35	БАРАА МАТЕРИАЛ	5,482,500	-
354	Хангамжийн материал	5,482,500	-
35440	Түлш, шатах тослох материал	3,330,000	-
35470	Бусад хангамжийн материал	2,152,500	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,679,778,225	3,429,783,930
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,679,778,225	3,429,783,930
51	Засгийн газрын хувь оролцоо	2,679,778,225	3,429,783,930
512	Хуримтлагдсан үр дүн	2,679,778,225	3,429,783,930
51210	Өмнөх үеийн үр дүн	2,432,009,870	2,669,778,225
51220	Тайлант үеийн үр дүн	247,768,355	760,005,705
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,679,778,225	3,429,783,930

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,483,016,725.52	2,600,837,247.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,320,575.52	92,674,247.24
120	Нийтлэг татварын бус орлого	182,320,575.52	92,674,247.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,320,575.52	92,674,247.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,320,575.52	92,674,247.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,300,696,150	2,508,163,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,300,696,150	2,508,163,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	61,440,200	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,239,255,950	2,508,163,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,235,248,370.52	1,840,831,542.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,248,370.52	1,840,831,542.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,940,200	1,350,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,000,000	1,350,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000	1,350,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,940,200	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,955,000	-

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,985,200	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,171,308,170.52	1,839,481,542.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	401,996,078	916,220,745
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	401,996,078	916,220,745
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	182,320,575.52	90,154,247.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	182,320,575.52	90,154,247.24
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	111,794,340
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111,794,340
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	586,991,517	721,312,210
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	586,991,517	721,312,210
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>247,768,355</u>	<u>760,005,705</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>247,768,355</u>	<u>760,005,705</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,483,016,725.52</u>	<u>2,603,502,247.24</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>182,320,575.52</u>	<u>92,674,247.24</u>
120	Нийтлэг татварын бус орлого	182,320,575.52	92,674,247.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,320,575.52	92,674,247.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,320,575.52	92,674,247.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,300,696,150</u>	<u>2,510,828,000</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	2,665,000
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	2,665,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,300,696,150	2,508,163,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	61,440,200	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,239,255,950	2,508,163,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,059,766,905.52</u>	<u>3,329,149,457.24</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,059,766,905.52</u>	<u>3,329,149,457.24</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>65,440,200</u>	<u>1,350,000</u>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	<u>7,500,000</u>	<u>1,350,000</u>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500,000	1,350,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>57,940,200</u>	<u>-</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,955,000	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,985,200	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>1,994,326,705.52</u>	<u>3,327,799,457.24</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	<u>1,222,349,613</u>	<u>2,395,018,660</u>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,222,349,613	2,395,018,660
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	<u>184,985,575.52</u>	<u>99,674,247.24</u>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,985,575.52	99,674,247.24

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	111,794,340
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111,794,340
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	586,991,517	721,312,210
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	586,991,517	721,312,210
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(576,750,180)	(725,647,210)
14	Бусад эх үүсвэр	576,750,180	725,647,210
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	576,750,180	725,647,210
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	576,750,180	725,647,210

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,679,778,225	2,679,778,225
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,679,778,225	2,679,778,225
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,679,778,225	2,679,778,225
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,679,778,225	2,679,778,225
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(10,000,000)	(10,000,000)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,669,778,225	2,669,778,225
D08	Тайлант үеийн үр дүн	760,005,705	760,005,705
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,429,783,930	3,429,783,930

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,508,163,000	2,396,368,660	111,794,340	95.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,508,163,000	2,396,368,660	111,794,340	95.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000	1,350,000	3,150,000	30.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000	1,350,000	3,150,000	30.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000	1,350,000	3,150,000	30.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,503,663,000	2,395,018,660	108,644,340	95.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,503,663,000	2,395,018,660	108,644,340	95.66
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,503,663,000	2,395,018,660	108,644,340	95.66
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,508,163,000	2,396,368,660	111,794,340	95.54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,508,163,000	2,396,368,660	111,794,340	95.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,508,163,000	2,396,368,660	111,794,340	95.54

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Халамжаас Хөдөлмөрт-Халамж хүртэгчдийг хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлж хандлагыг нь өөрчлөх орлоготой болгох, амьжиргааг дээшлүүлэх”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

ХЭДС -гаас 2022 онд 1500 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, 1100 иргэнийг ажлын байранд зуучилж, 3061 иргэнийг зээлийн өмнөх болон дараах сургалт, үйлдвэр дээрх сургалт, мэргэжил олгох, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, 232 иргэнд санхүүгийн дэмжлэг олгож байнгын ажлын байрыг нэмэгдүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байна.

Тайлант онд 73 иргэнийг малжуулах төсөлд, 42 иргэнийг ХБИ-ний, 165 иргэнийг ажлын байрыг дэмжих, 882 иргэнийг мод тарих болон нийтийг хамарсан ажилд хамруулан түр ажлын байраар хангасан, 122 ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулан, 521 иргэнд ганцаарчилсан, 1288 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилсан, 737 иргэнийг зээлийн өмнөх олон дараах, үйлдвэр дээрх, мэргэжил олгох, хөдөлмөрт бэлтгэх сургалтуудад, 105 иргэнийг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тус тус хамруулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ХЭДСан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Татвар болон Нийгмийн даатгалын тухай хууль болон харьяа яамнаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, “Ногоон ажлын байр” хөтөлбөрүүд шинээр нэмэгдсэн, бусад мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх дотоод хяналтын албанаас 2022 онд ХЭДС-ийн зээлийн эргэн төлөлт, санхүүгийн дэмжлэгт хамрагдах төсөл хөтөлбөрүүдэд 3 удаа хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХЭДСангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 750.0 сая төгрөгөөр буюу 28.0 хувиар өссөн нь авлагын данстай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,654.6	3,429.8	775.2
Урьдчилж гарсан зардал	19.7		(19.7)
Бараа материал	5.5		(5.5)
Нийт хөрөнгө	2,679.8	3,429.8	750.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,679.8	3,429.8	750.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,679.8	3,429.8	750.0

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ 2022 оны санхүүгийн тайлан дахь авлага 3,429.8 сая төгрөгийн 1139 иргэнтэй холбоотой, үүнээс тайлант онд 352 иргэнд 1,504.0 сая төгрөгийн авлага, өмнөх онуудад үүссэн 1,925.8 сая төгрөгийн авлага байна. Нийт авлагын 38.2 буюу 1,307.4 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн, нас барсан, хуулийн байгууллагад шилжүүлсэн авлага эзэлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,890.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 505.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,533.2 сая төгрөгөөр баталсан нь хөтөлбөр арга хэмжээний эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн эх

үүсвэрийн хэмжээ 1 дахин, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Ногоон ажлын байр” гэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд анх батлагдсан 2,423.9 сая төгрөгийн төсвийг 2022 онд 2 удаа тодотгон баталж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,508.2 сая төгрөгийг улсын төсвөөс, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 25.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,396.3 сая төгрөгийн санхүүжилт, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоор 92.5 нийт 2,487.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн төвлөрүүлж, батлагдсан төсвийг 95.5 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
72102 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
1	72102/80224 - Зөвлөл, хороо, комиссын гишүүд	4.5	1.3	3.2	28.9
2	72102 /82602- ХБИ-н ажлын байрыг дэмжих	213.2	186.8	26.4	87.6
3	72102/82604-Аж ахуй эрхлэлтийг дэмжих	1,385.4	1,356.8	28.6	97.9
4	72102/82606-залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	51.9	30.4	21.5	58.6
5	72102/82609-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	253.2	253.2	-	100
6	72102/82612- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх	24.0	24.0	-	100
7	72102/82613- Ажилд зуучлах	11.0	11.0	-	100
8	72102/82616-Засгийн газрын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	465.6	434.1	31.6	93.2
9	72102/82618- Хөдөлмөрт бэлтгэх	99.2	98.7	0.5	99.5
ДҮН		2,508.2	2,396.3	111.8	95.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу

Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 13-наас 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 35 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,235.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 24.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,840.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 36.8 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 25.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь энэ хуулийн 5 дугаар зүйлд Тэргүүн дэд, дэд орлогч дарга, 6 дугаар зүйлд тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилот, 10 дугаар зүйлд цалин хөлс, нэмэгдэл, 11 дүгээр зүйлд нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 12 дугаар зүйлд бусад хангамж, 13 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан холбоотой заалтууд хамаарахгүй байна.

15 дугаар зүйлд заасан бусад зардлын хувьд Эмэгтэйчүүд гэр бүл сэтгэл зүйн, Хүүхэд хамгааллын чиглэлийн урамшуулал, Хөдөлмөр аюулгүй байдал, хөдөлмөрийн шинэ хуулийн талаар сургалт зохион байгуулахад 5.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроосон, 137 мэдээллийг хугацаандаа оруулсан, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 81.8 хувтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2.8	1	2.8	100
Албан шаардлага	1	36.4	1	36.4	100
Зөвлөмж	4	39.6	2	18	45.5
Нийт дүн	6	78.8	4	57.2	81.8

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 9.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, албан шаардлага, 7.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сумдад томилолтоор ажиллаагүй мэргэжилтэнд 1.8 сая төгрөгийн томилолтын мөнгө олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1 Өмнөх СТА-аар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, сангийн зээлд хамрагдаж төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгч нь тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, гэрээнд заасан чиг үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн гэрээний 4.5-д "Б тал энэхүү гэрээний дагуу олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан, бусдад дамжуулсан, ашиглуулсан, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд А талд учруулсан хохирол (шүүхийн зардал, үндэсний аудитын байгууллагын акт, улсын байцаагчийн албан шаардлага, актаар тогтоогдсон) олгосон санхүүгийн дэмжлэгийг эргүүлж нөхөн төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

5.2.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, сумдын мэргэжилтнүүд төсөл хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилт, ажлын байр нэмэгдүүлсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд 1.8 сая төгрөгийн шатахууны зардалд гаргасан ажлын тайлан бүрэн бус, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтыг мөрдөн ажиллах, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

5.2.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бадрал холбоо ТББ-тай "хөдөлмөрийн тухай хууль, ХАБ" -ын чиглэлээр сургалт хийхээр гэрээ байгуулж гүйцэтгэлээр хэдэн байгууллагын хэчнээн хүнд сургалт хийсэн нотлох анхан шатны баримтгүй, сургалтын чиглэл давхардсан, Хүүхэд хамгааллын урамшуулалд 5.8 сая төгрөгийг зарцуулж үр дүн хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сургалтыг зорилтот бүлгийн иргэдийг хамруулах, үр дүнг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалтыг мөрдөн ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс								
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, сумдын мэргэжилтнүүд төсөл хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилт, ажлын байр нэмэгдүүлсэн эсэхэд хяналтын шатахууны зардалд гаргасан ажлын тайлан бүрэн бус, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй	1	1.8					1	1.8
Өмнөх СТА-аар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, сангийн зээлд хамрагдаж төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгч нь тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, гэрээнд заасан чиг үүргээ биелүүлээгүй	1				1			-
Анхан шатны баримтгүй, цагийн бүртгэлд томилолтоор ажилласан талаар бүртгэл хөтлөөгүй томилолтын мөнгө олгосон	1	1.8	1	1.8				-
Дүн	3	3.6	1	1.8	1		1	1.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая. төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сургалтын сэдвийг давхардуулсан, удирдамжид заасан сургалтаа бүрэн хийгээгүй, хэчнээн хүн хамруулсан эсэх тодорхойгүй, анхан шатны баримт дутуу, Хүүхэд хамгааллын урамшуулалд зарцуулсан, сангийн хөрөнгийн үр дүн хангалтгүй дутагдал илэрлээ	1	5.8	-	-	-	-	1	5.8
Дүн	1	5.8	-	-	-	-	1	5.8

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 11/А2160424

Ховд

**ХОА-2022/02/НА/СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд Малжуулах хөтөлбөрийн хүрээнд сумдад томилолтоор ажилласан хугацаа цагийн бүртгэлийн дэвтрийн бүртгэлтэй тулгахад зөрүүтэй бүртгэсэн томилолтоор ажиллаагүй албан хаагчдад томилолтын мөнгө олгосон 1856.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1856000 /нэг сая найман зуун тавин зургаан мянган төгрөг/-ийг төсвийн шууд захирагч, сан хариуцсан мэргэжилтэн нараар төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 05-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэл, сан хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч Б.Саранцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЯДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

1 Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061